



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, 13/1, Утас: 26-63-09, Факс: 32-99-33
E-mail: info@cd.gov.mn, http://www.cd.gov.mn/

2017. 4. 25 № 03/1490


танай _____-ны № _____-т

**「 ХОРИХ АНГИ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
АЛБА, САЛБАР НЭГЖИЙН
ДАРГА НАРТ**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар ШШГЕГ-ын “Ёс зүйн хороо” байгуулсныг үүгээр хүргүүлж байна.

“ШШГБ-ын ажилтны ёс зүйн дүрэм”-ийн 7.2-т заасны дагуу хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжүүд “Салбар хороо”-г байгуулж, үйл ажиллагааны хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр ШШГЕГ-ын “Ёс зүйн хороо”-нд тайлагнаж байхыг мэдэгдье.

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА



М.АЛТАН-ОЧИР



**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар

А/91

Улаанбаатар хот

Ёс зүйн хороо байгуулах тухай

“Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, ШШГЕГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ёс зүйн дүрэм”-ийн 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Ёс зүйн хороо”-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн дэд дарга

Нарийн бичгийн дарга:

Захиргааны удирдлагын газрын Төлөвлөлт, дүн
шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Захиргааны удирдлагын газрын Хууль тогтоомжийн
хэрэгжилт, дотоод ажлын хэлтсийн дарга

Тогтоол гүйцэтгэх газрын Мэргэжлийн удирдлага,
харуул хамгаалалтын хэлтсийн дарга

Шийдвэр гүйцэтгэх газрын Мэргэжлийн удирдлагын
хэлтсийн дарга

Санхүү, хангамжийн газрын Санхүү, эдийн засаг,
үйлдвэрийн хэлтсийн дарга

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газрын
Бүртгэл, хяналт хариуцсан тасгийн дарга

Дотоод аюулгүй байдал, хяналт шалгалтын
газрын хяналт шалгалтын асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн

2. Ёс зүйн хороо нь ШШГБ-ын ажилтны сахилга, ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг шалгасан дүнг хэлэлцэн, дүгнэлт гаргаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлэж байхыг Ёс зүйн хорооны даргад, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын даргад тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2011 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/43 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Ц.АМГАЛАНБАЯР

0000106